



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/385

Булган сум

Дотоод аудитын хорооны гишүүдийг шинэчлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.13, 4.14 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Дотоод аудитын хорооны дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын төлөвлөгөөг батлах, төсвийн Ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Дотоод аудитын хороо”-нд өөрчлөлт оруулсугай. Үүнд:

Дарга:	Аймгийн Засаг дарга
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх, зүйн сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Булган салбарын гишүүн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Иргэний төлөөлөл Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч

2. Дотоод аудитын хорооны үйл ажиллагааг дүрмийн дагуу зохион байгуулж, тайланг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга (Б.Баттулга)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын “Дотоод аудитын хорооны гишүүдийг шинэчлэх тухай” 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/373 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д. ПҮРЭВ-ОЧИР

Дугаар Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж

6325010619